

## 10

## БИЗНЕСИЙН НЭГДЛИЙН БҮРТГЭЛ ТАЙЛАГНАЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Д.Нямаа

СТОУС-3-т зааснаар *Бизнесийн нэгдэл /Business combination/* гэж тусдаа аж ахуйн нэгжүүд буюу бизнесүүдийг нэг тайлагнагч аж ахуйн нэгжид нэгтгэхийг хэлэх бөгөөд *бизнес* гэдэг нь хөрөнгө оруулалтыг нөхөх эсвэл бизнесийн үйл ажиллагааны зардлыг бууруулах эсвэл хамтарсан үйл ажиллагаа явуулсны үр дүнд нэмэлт өгөөж бий болгох зорилгоор явуулж буй цогц үйл ажиллагаа юм.

Аливаа бизнест амжилт олоход тухайн бизнесийн нэгжийн хэмжээ, цар хүрээ нөлөөтэй бөгөөд хууль эрх зүйн байдал, татварын нөхцөл болон бусад шалтгаанаар нэг аж ахуйн нэгж нөгөө аж ахуйн нэгжийн өмч буюу цэвэр хөрөнгийг бүхэлд нь, эсвэл цэвэр хөрөнгийн зарим хэсгийг, эсвэл нийт хөрөнгийг худалдаж авах замаар бизнесийн нэгдлийг үүсгэдэг байна. Бизнесийн нэгдлийг /horizontal/ хэвтээ чиглэлийн буюу I салбар дахь бизнесүүдийн нэгдэл, /vertical/ босоо чиглэлийн буюу тухайн аж ахуйн нэгж худалдан авагч эсвэл бэлтгэн нийлүүлэгчтэйгээ нэгдсэн бизнесийн нэгдэл, /conglomerate/ конгломерат чиглэлийн буюу салбар эсвэл зах зээлтэйгээ ямар ч холбоогүй бизнесүүдийн нэгдэл гэж ангилж болно. Бизнесийн нэгдлийн үр дүнд шинэ хүчтэй удирдлагын баг бүрдэх бөгөөд эсвэл өмнөх удирдлагууд үйл ажиллагаандаа амжилт олохын тулд илүү сайн ажилладаг, орлогын татварын давуу байдлыг эдэлдэг гэх мэт давуу талуудтай.

Бизнесийн нэгдлийн худалдан авалтын үндсэн хэлбэрүүд нь дараах байдалтай байна. Үүнд:

- *Хууль ёсоор нэгтгэх (Statutory Merger)*
- *Хууль ёсоор нэгдэх (Statutory combination)*
- *Хөрөнгийг худалдан авах (Acquisition Assets)*
- *Саналын эрхтэй хувьцааг худалдан авах (Acquisition of Voting stock)*

Хууль ёсоор нэгтгэнэ гэдэг нь I компани нөгөө компанийн гүйлгээнд байгаа бүх хувьцаанд зориулан энгийн хувьцаа шинээр гаргаж болохыг бизнесийн нэгдэлд нэгдэж байгаа аж ахуйн нэгжүүдийн захирлын зөвлөл зөвшөөрсөн нөхцөл юм. Өөрөөр хэлбэл, хууль ёсны нэгтгэгч нь нөгөө компанийн цэвэр хөрөнгийг бүрэн эзэмших эрхтэй болж байгаа тул энэ нөхцөлд нэгтгэгчээс бусад компаниуд татан буугддаг.

Хууль ёсоор нэгдэнэ гэдэг нь дээрх хэлбэртэй төстэй бөгөөд хоёроос дээш тооны компаниудын гүйлгээнд байгаа бүх энгийн хувьцааг олж авахын тулд өөр нэг компани шинээр энгийн хувьцаа гаргаж байгаа хэлбэр. Энэ нөхцөлд шинэ компани дээрх компаниудын цэвэр хөрөнгийг олж авч байгаа тул нэгдэгч компаниуд татан буугдана.

Хөрөнгийг худалдан авах хэлбэрийн үед нэг бизнесийн нэгж өөр нэг аж ахуйн нэгжийн нийт хөрөнгийг бүхэлд нь, эсвэл хөрөнгийн дийлэнхийг мөнгөөр, эсвэл өглөг үүсгэн, эсвэл хувьцаа гаргах замаар олж авч болно. Дээрх ажил гүйлгээг бизнесийн нэгдлийн бүрэлдэхүүн компаниудын захирлын зөвлөл болон хувьцаа эзэмшигчид ерөнхийдөө зөвшөөрсөн байх ёстой. Энэ нөхцөлд хөрөнгөө худалдаж байгаа аж ахуйн нэгж тусдаа аж ахуйн нэгж байхыгаа үргэлжлүүлж болно эсвэл татан буугдаж ч болно. Гэхдээ, дээрх аж ахуйн нэгж нь хөрөнгийг худалдан авч байгаа аж ахуйн нэгжийн охин компани болохгүй.

Саналын эрхтэй хувьцааг худалдан авах хэлбэрийн үед хөрөнгө оруулагч гэгдэх нэг компани санхүүжигч гэгдэх өөр нэг компанийн энгийн хувьцааг бүхэлд нь, эсвэл түүний дийлэнх хэсгийг олж авахын тулд давуу эрхтэй юм уу эсвэл энгийн хувьцаа гаргаж, мөнгө төлж, өглөг үүсгэж болох юм. Хувьцаа олж авах энэхүү үйл ажиллагаа нь үнэт цаасны зах зээлээс худалдан авах, эсвэл компанийн хувьцаа эзэмшигчидээс голлох хувийг эзэмшигчидтэй нь тохиролцох, эсвэл тендер саналаар дамжин хэрэгжиж болно.

Хэрвээ нэгдэгч компанийн саналын эрхтэй энгийн хувьцааны 50 хувиас илүүг хөрөнгө оруулагч олж эзэмшвэл, энэхүү хөрөнгө оруулагч толгой компани /parent/ болох ба санхүүжигч компани нь охин компани /subsidiary/ болно. Энэ нөхцөлд охин компани татан буугдахгүй бөгөөд хуулийн этгээд хэвээрээ үлдэнэ.

Бизнесийн нэгдэл нь толгой болон охин компанийн харилцан хамаарлын үр дүн бөгөөд худалдан авсан аж ахуйн нэгж нь толгой компани, эзэмшилд орсон аж ахуйн нэгж нь түүний охин компани болно.

Компанийн тухай Монгол улсын хуульд ч “Компанийн нийт энгийн хувьцааны 51-100 хүртэлх хувийг өөр (толгой) компани дангаараа эзэмшдэг бие даасан хуулийн этгээдийг охин компани гэнэ. Охин компани нь тусдаа санхүүгийн тайлан гаргахын зэрэгцээ толгой компанитайгаа нэгтгэсэн тайлан гаргана” гэж заасан байдаг.

Толгой компани нь нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргалтандаа “Бизнесийн нэгдэл” хэмээх СТОУС-3-ыг ашиглах ба тусдаа санхүүгийн тайландаа “Нэгтгэсэн ба тусдаа санхүүгийн тайлан” хэмээх НББОУС-27-ын дагуу

хяналтандаа авсан аж ахуйн нэгж дэх хувь оролцоогоо “Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт” гэж тайлагнана.

#### **Бизнесийн нэгдлийн нягтлан бодох бүртгэлийн арга**

Ихэнх бизнесийн нэгдэлд нэг нэгтгэгч, нэг болон түүнээс дээш тооны нэгдэгч багтдаг учраас уг нэгдлийг хэрхэн үүсгэж байгаагаас үл хамааруулан хөрөнгө худалдан авч байгаагаар бүртгэх нь зүйтэй гэж үздэг. Ийм учраас хөрөнгийг мөнгөөр худалдаж авсан бол төлөгдсөн мөнгөний дүнгээр, хөрөнгийг худалдаж авахын тулд өрийн үнэт цаас, давуу эрхтэй эсвэл энгийн хувьцаа гаргасан бол хөрөнгийн тухайн үеийн бодит үнэ цэнэ /зах зээлийн үнэ цэнэ/, эсвэл хувьцаа, өрийн бичгийн тухайн үеийн зах зээлийн үнийн аль тодорхойгоор нь бүртгэдэг.

Бизнесийн нэгдэл нь худалдан авалтын аргыг ашиглан нягтлан бодох бүртгэлээ хөтлөхдөө дараах үе шатуудыг гүйцэтгэх шаардлагатай. Үүнд:

а. худалдан авагчийг тодорхойлно;

б. бизнесийн нэгдлийн өртгийг хэмжинэ;

в. худалдан авалтын өдрөөр бизнесийн нэгдлийн өртгийг худалдан авсан хөрөнгө, тооцсон өр төлбөр болон болзошгүй өр төлбөрт хуваарилна.

Болзошгүй өр төлбөр гэдэг нь аж ахуйн нэгж, байгууллагын удирдаж, хянах бололцоогүй, ирээдүйд үүсэх нөхцлөөр батлагдаж, өнгөрсөн үйл явдлуудын үр дүнд бий болсон боломжит өр төлбөр, өр төлбөрийг төлөхийг шаардахгүй эсвэл өр төлбөрийн дүнг баталгаатай хэмжих боломжгүйн улмаас хүлээн зөвшөөрөхгүй байгаа өнгөрсөн үйл явдлуудын үр дүнд бий болсон өнөөгийн өр төлбөр юм.

Худалдан авагч гэж бусад нэгдэж байгаа аж ахуйн нэгжүүд буюу бизнесүүдийг хяналтандаа авсан бизнесийн нэгжийг хэлэх бөгөөд худалдан авагч нь бизнесийн нэгдлийн өртгийг дараах байдлаар хэмжих ёстой. Үүнд:

а. Худалдан авч буй компанид хяналтаа хэрэгжүүлэхийн тулд арилжааны өдрөөр худалдан авагчийн гаргасан өмчийн үнэт цаасны бодит үнэ цэнэ, авсан хөрөнгө болон тооцоолсон өр төлбөрийн бодит үнэ цэнэ;

б. бизнесийн нэгдэлд шууд хамаарах зардлууд зэрэг болно.

Арилжааны өдрөөр авсан хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо дараах үнэлгээг ашиглана.

- *Идэвхтэй зах зээлд хөрвөж байгаа санхүүгийн хэрэглүүрийн хувьд* – зах зээлийн үнэ
- *Идэвхтэй зах зээлд хөрвөхгүй байгаа санхүүгийн хэрэглүүрийн хувьд* – үнэлгээний үнэ цэнэ. Үнэлгээний үнэ цэнэд хувьцааны үнэ орлогын харьцаа, ноогдол ашгийн орлого зэрэг хүчин зүйлсийг харгалзаж үзнэ.
- *Өр төлбөрийн хувьд* – дискаунтчилсан өртөг. Энэ өртгийг хүүгийн хувь хэмжээгээр тооцоолсон дүнгээс найдваргүй байж болзошгүй өр төлбөрүүдийг хасч тооцно. Дискаунтчилах нь материаллаг зөрүү

үүсгэхгүй бол богино хугацаагаар өр төлбөрийг дискаунтчилах шаардлагагүй.

• *Бараа материалаарх хөрөнгө:*

(а) Бэлэн бүтээгдэхүүн – борлуулалтын үнээс борлуулалтын зардал болон ашгийн хувь хэмжээг хассан дүн. Ашгийн нормыг байгууллага болон борлуулалтын онцлог, ижил төрлийн бэлэн бүтээгдэхүүний ашгийн хэмжээнээс хамааруулан тогтооно.

(б) Дуусаагүй үйлдвэрлэл – бэлэн бүтээгдэхүүний борлуулалтын үнээс бүтээгдэхүүнийг бэлэн болгох зардал, борлуулалтын зардал болон ашгийн хувь хэмжээг хассан дүн.

(в) Түүхий эд, материал – ижил төрлийн түүхий эд, материалын худалдан авах үнэ цэнэ.

• *Газар, барилга байгууламжийн хувьд* – зах зээлийн үнэ цэнэ

• *Машин, тоног төхөөрөмжийн хувьд* – мэргэжлийн үнэлгээний тодорхойлсон зах зээлийн үнэ цэнэ. Хэрэв үндсэн хөрөнгийн шинж чанараас хамааран эсвэл тухайн хөрөнгө нь маш ховор зарагддаг тул зах зээлийн баталгаатай үнэ байхгүй бол худалдан авагч үндсэн хөрөнгийг ашигласнаас үүсэх орлогыг тодорхойлох эсвэл түүний үлдэгдэл өртгийг тооцох замаар бодит үнэ цэнийг тодорхойлох шаардлагатай.

• *Биет бус хөрөнгийн хувьд* – НББОУС 38-ийн дагуу идэвхтэй зах зээл дээрх үнэ эсвэл идэвхтэй зах зээл оршин байхгүй бол худалдан авагч хэлцэл хийх сонирхолтой, хараат бус талтай биет бус хөрөнгийг худалдан авахад гаргасан зардал.

• *Тогтмол төлбөртэй тэтгэврийн төлөвлөгөөний цэвэр хөрөнгө эсвэл өр төлбөрийн хувьд* – ажилтан, албан хаагчдад олгох цалин хөлсний тогтмол өр төлбөрөөс тэтгэврийн төлөвлөгөөний хөрөнгийн бодит үнэ цэнийг хассан дүн.

Бизнесийн нэгдэлд шууд хамаарах зардлуудыг нэгтгэгчийн халаасны гаднах шууд зардал гэж нэрлэх бөгөөд үүнд нягтлан бодогч, хуулийн зөвлөх, үнэлгээчин болон бусад зөвлөхүүдэд төлсөн мэргэжлийн үйлчилгээний хөлс, хөрөнгө оруулалтын банк, брокерийн пүүс, эсвэл бусад байгууллага, хувь хүмүүст нэгдэгчийг судлах, бизнесийн нэгдлийн үнийг тодорхойлох зэрэгтэй холбоотой гарсан зардлууд багтана. Харин, өрийн болон өмчийн үнэт цаас гаргах, хэвлэх, бүртгүүлэх зардлууд нь бизнесийн нэгдлийн шууд зардал биш учраас эдгээрийг гаргасан үнэт цаасны орлогоос суутгах буюу бондын өглөгийн урамшуулал, нэмж төлөгдсөн капитал зэрэг дансдын Дт-д бичнэ. Нэгтгэгчийн халаасны гаднах шууд бус зардлын бүрэлдэхүүнд бизнесийн нэгдлийг бий болгох, хэлэлцээрт оролцсон албан хаагчдын цалин хөлс, бүрэлдэхүүн компаниудын зардал бас орно.

Худалдан авч эзэмшихтэй шууд холбогдолгүй зардлуудыг гарсан тухайд нь зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Худалдан авагч худалдан авалтын өдрөөр бизнесийн нэгдлийн өртгийн худалдан авч эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөр болон болзошгүй өр төлбөрийн бодит үнэ цэнэ дэх худалдан авагчийн хувь оролцооноос давсан дүнг гүүдвил хэмээн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч анх өртгөөр нь бүртгэх ёстой.

*Гүүдвиллийн бүртгэл, тайлагнал*

Гүүдвиллийн өртгийг тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөр, нэн ялангуяа болзошгүй өр төлбөрийн худалдан авалтын өртөг болон бодит үнэ цэнийн зөрүүгээр илэрхийлдэг бөгөөд дараах томъёогоор тооцоолно:

$$Г = БНӨ - ТЦХ_{6y}$$

Үүнд: Г - Гүүдвилл

БНӨ - Бизнесийн нэгдлийн өртөг буюу худалдан авалтын үнэ

ТЦХ<sub>6y</sub> - Тодорхойлогдох цэвэр хөрөнгө бодит үнэ цэнээр

Тодорхойлогдох цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнэ =

= Хөрөнгийн бодит үнэ цэнэ - Өр төлбөр болон болзошгүй өр төлбөрийн бодит үнэ цэнэ

Хэрэв бизнесийн нэгжийн цэвэр хөрөнгийн 100 хүртэлх хувийг худалдан авч байгаа бол гүүдвиллийг дараах томъёогоор тодорхойлно.

$$Г = БНӨ - ТЦХ_{6y} \times X \%$$

Үүнд: % - Бизнесийн цэвэр хөрөнгөнөөс худалдан авсан хувь хэмжээ

Бизнесийн нэгдлийн дүнд үүссэн гүүдвиллийг хорогдуулахгүй. Харин НББОУС 36 "Хөрөнгийн үнэ цэнийн бууралт"-ийн дагуу үнэ цэнийн бууралтыг жил бүр тестэлж өртгөөс нь аливаа хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр санхүүгийн тайланд толилуулах нь зүйтэй юм.

Хэрвээ худалдан авсан тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөр болон болзошгүй өр төлбөрийн бодит үнэ цэнэ дэх худалдан авагчийн хувь оролцоо бизнесийн нэгдлийн өртгөөс давж байвал худалдан авагч худалдан авсан тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөр болон болзошгүй өр төлбөрийн хэмжилт болон тодорхойлолт, бизнесийн нэгдлийн өртгийн хэмжилтийг дахин шалгаж, дахин шалгасны дараах аливаа зөрүү-сөрөг гүүдвиллийг тайлант үеийн ашиг эсвэл алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Худалдан авалтын хэлбэр тус бүрийн нөхцөлд бизнесийн нэгдлийг хэрхэн бүртгэхийг жишээгээр авч үзье.

**1. Хууль ёсоор нэгтгэх хэлбэрээрх бизнесийн нэгдэл:**

2007 оны 6 дугаар сарын 30-нд "Од" компани "Нар" компанийг хууль ёсоор нэгтгэсэн. Үүний тулд, нэгжийн 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 150000 ш хувьцааг /нэгжийн зах зээлийн үнэ нь 25 төг/ "Нар" компанийн гүйлгээнд байгаа 100000 ш хувьцаанд зориулан гаргасан, мөн халаасны гаднах зардалд 200000 төг төлсөн. Үүнд:

|                                    |                   |
|------------------------------------|-------------------|
| Санхүүгийн тайлангийн аудитын хөлс | 60000             |
| Хууль зүйн төлбөр                  | 10000             |
| ҮЦ хороонд бүртгүүлсний хөлс       | 50000             |
| Зуучлалын хөлс                     | 56250             |
| Үнэт цаас хэвлүүлэх зардал         | 23000             |
| Бусад                              | 750               |
| <b>Бүгд:</b>                       | <b>200000 төг</b> |

Нэгтгэх гэрээнд ямар нэг болзошгүй төлбөр байгаагүй.

| "Нар" ХК  |                |                       |                |
|---|----------------|-----------------------|----------------|
| Баланс /Бизнесийн нэгдлийн өмнөх байдлаар/<br>2007 оны 6 сарын 30 |                |                       |                |
| Хөрөнгө   |                | Өглөг ба ХЭ Өмч       |                |
| Эргэлтийн хөрөнгө   | 1000000        | БХ өглөг              | 500000         |
| Үндсэн хөрөнгө  | 3000000        | УХ өглөг              | 1000000        |
| Бусад хөрөнгө   | 600000         | Энгийн хувьцаа        | 1000000        |
|   |                | НТ Капитал            | 700000         |
|   |                | Хур/ашиг              | 1400000        |
| <b>Хөрөнгийн дүн</b>  | <b>4600000</b> | <b>Өглөг, ХЭӨ дүн</b> | <b>4600000</b> |

"Нар" компанийн цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлбол:

|                                    |                |
|------------------------------------|----------------|
| Эргэлтийн хөрөнгө                  | 1150000        |
| Үндсэн хөрөнгө                     | 3400000        |
| Бусад хөрөнгө                      | 600000         |
| БХ өглөг                           | (500000)       |
| УХ өглөг /Өнөөгийн үнээр/ (950000) |                |
| <b>Бүгд:</b>                       | <b>3700000</b> |

"Од" хууль ёсны нэгтгэгч компанийн хувьд дараах журналын бичилтийг хийнэ.

а/"Нар" ХК-ийг нэгтгэж буй бичилт:

|                              |         |
|------------------------------|---------|
| "Нар" компани дахь хув-х ХО  | 3750000 |
| /150000 х 25 т/              |         |
| Энгийн хувьцаа /150000 х 10/ | 1500000 |
| Нэмж төлөгдсөн капитал       |         |

2250000

б/Халаасны гаднах зардлын төлбөрийн бичилт:

|                             |        |
|-----------------------------|--------|
| "Нар" компани дахь хув-х ХО | 66250  |
| НТ Капитал                  | 133750 |
| Мөнгөн хөрөнгө              | 200000 |

в/"Нар" компани дахь ХО-ын өртгийг хуваарилсан бичилт:

|                              |         |
|------------------------------|---------|
| Эргэлтийн хөрөнгө            | 1150000 |
| Үндсэн хөрөнгө               | 3400000 |
| Бусад хөрөнгө                | 600000  |
| Урт хугацаат өрийн хөнгөлөлт | 50000   |
| Гудвилл                      | 116250  |
| БХ өглөг                     | 500000  |
| Урт хугацаат өр              | 1000000 |
| "Нар" ком.дахь хув-х ХО      | 3816250 |

Гүүдвилийн тооцоолол:

|   |          |
|---|----------|
| ХО-ын өртөг= Нэгдэгчийн өртөг=              | 3816250  |
| Цэвэр хөрөнгө /нэгдэгчийн/ балансын дүнгээр | 4600000  |
|   | -1500000 |
| <b>3100000</b>                              |          |

Цэвэр хөрөнгийн балансын дүнгээс давж буй бодит үнэ цэнэ:

|                      |                   |
|----------------------|-------------------|
| Эргэлтийн хөрөнгө -  | 150000            |
| Үндсэн хөрөнгө -     | 400000            |
| Урт хугацаат өглөг - | 50000             |
| <b>Бүгд:</b>         | <b>600000 төг</b> |

$3816250 - 3100000 + 600000 = 116250$

Татан буугдаж байгаа "Нар" компанид дараахь бичилт хийгдэнэ.

|                   |         |
|-------------------|---------|
| Эргэлтийн хөрөнгө | 1000000 |
| Үндсэн хөрөнгө    | 3000000 |
| Бусад хөрөнгө     | 600000  |

|            |         |
|------------|---------|
| БХ өглөг   | 500000  |
| УХ өглөг   | 1000000 |
| Э Хувьцаа  | 1000000 |
| НТ Капитал | 700000  |
| Хур/ашиг   | 1400000 |

**2.Хууль ёсоор нэгдэх хэлбэрээрх бизнесийн нэгдэл:**  
"Уян" компани ба "Угалз" компани

| Баланс                                |                |                |
|---------------------------------------|----------------|----------------|
| 2007 оны 9 сарын 30                   |                |                |
| Хөрөнгө:                              | Уян            | Угалз          |
| Эргэлтийн хөрөнгө                     | 600000         | 400000         |
| Үндсэн хөрөнгө                        | 1800000        | 1200000        |
| Бусад хөрөнгө                         | 400000         | 300000         |
| <b>Хөрөнгийн дүн:</b>                 | <b>2800000</b> | <b>1900000</b> |
| Өглөг ба хувьцаа эзэмшигчдийн өмч:    |                |                |
| БХ өглөг                              | 400000         | 300000         |
| УХ өглөг                              | 500000         | 200000         |
| Энгийн хувьцаа                        | 430000         | 620000         |
| Нэмж төлөгдсөн капитал                | 300000         | 400000         |
| Хуримтлагдсан ашиг                    | 1170000        | 380000         |
| Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн: | <b>2800000</b> | <b>1900000</b> |

Дээрх 2 компанийн өр төлбөрийн тухайн үеийн бодит үнэ дансны үнэтэйгээ тэнцүү байсан. Хөрөнгийн тухайн үеийн бодит үнэ харгалзан: Эргэлтийн хөрөнгө 800000 ба 500000, Үндсэн хөрөнгө 2000000 ба 1400000, бусад хөрөнгө 500000 ба 400000 төг. 2007 оны 9 дугаар сарын 30-нд дээрх 2 компанийн хувьцаа эзэмшигчид зөвшөөрсөн тул "Монгол савхи" хэмээх шинэ компани 74000 ш хувьцаа гаргасан. Энэ хувьцаа нь нэрлэсэн үнэгүй ба зөвшөөрсөн дүн нь нэгжид 60 төг.

Угалз, Уян компаниудын цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлбол:

|                                     | Уян:           | Угалз:         |
|-------------------------------------|----------------|----------------|
| Цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнэ:     |                |                |
| Уян: 800000+2000000+500000-900000   | 2400000        |                |
| Угалз: 500000+1400000+400000-500000 |                | 1800000        |
| Гүүдвил /goodwill/                  | 180000         | 60000          |
| <b>Бүгд:</b>                        | <b>2580000</b> | <b>1860000</b> |
| Шинэ компанийн хувьцаа:             | 43000 ш        | 31000 ш        |

"Монгол савхи" компанийн бүртгэлийн бичилт:  
а/Уян, Угалз компаниуд нэгдсэний бичилт:

|  |         |
|--|---------|
| Угалз, Уян компани дахь энгийн хувьцаагаарх хөрөнгө оруулалт | 4440000 |
|--|---------|

/74000 х 60төг/

|  |         |
|--|---------|
| Энгийн хувьцаа   | 4440000 |
| б/Халаасны зардлын төлбөрийн бичилт:                         |         |
| Угалз, Уян компани дахь энгийн хувьцаагаарх хөрөнгө оруулалт | 110000  |
| Энгийн хувьцаа   | 90000   |
| Мөнгөн хөрөнгө   | 200000  |

в/ Энэ тохиолдолд Уян компани нь Монгол савхи компанийн энгийн хувьцааны 58 хувийг эзэмшиж байгаа тул нэгтгэгч болно.

Иймээс Уянгийн цэвэр хөрөнгийг балансын дүнгээр нь Угалзын цэвэр хөрөнгийг зах зээлийн үнээр нь бүртгэнэ.

|   |                   |         |
|---|-------------------|---------|
| Эргэлтийн хөрөнгө                       | /600000+500000/   | 1100000 |
| Үндсэн хөрөнгө                          | /1800000+1400000/ | 3200000 |
| Бусад хөрөнгө                           | /400000+400000/   | 800000  |
| Гүүдвил                                 |                   | 850000  |
| БХ өглөг                                | /400000+300000/   | 700000  |
| УХ өглөг                                | /500000+200000/   | 700000  |
| Угалз, Уян компани дахь энгийн хувь. ХО |                   | 4550000 |

Гүүдвилын тооцоолол:

|  |           |
|--|-----------|
| ХО-ын өртөг: /4440000+110000/                          | 4550000   |
| Хасах нь: "Уян" компанийн цэвэр хөрөнгийн балансын дүн | (1900000) |
| "Угалз" компанийн цэвэр хөрөнгийн зах зээлийн үнэ      | (1800000) |
| Гүүдвил  | 850000    |

**3.Хөрөнгийг худалдаж авах хэлбэрээрх бизнесийн нэгдэл:**

2007 оны 9 дугаар сарын 30-нд "А" компани "Б" компанийн нийт хөрөнгийг 400000 төгрөгөөр худалдан авсан ба хууль зүйн төлбөрт 40000 төг төлжээ. "Б" компанийн бизнесийн нэгдлийн өмнөх баланс, холбогдох тухайн үеийн зах зээлийн үнийн талаарх мэдээлэл дараахь байдалтай байв.

"Б" компани  
Баланс  
2007 оны 9.30

|                    | Балансын дүн:  | Зах зээлийн үнэ: |
|--------------------|----------------|------------------|
| Эргэлтийн хөрөнгө  | 190000         | 200000           |
| Богино хугацаат ХО | 50000          | 60000            |
| Үндсэн хөрөнгө     | 870000         | 900000           |
| Биет бус хөрөнгө   | 90000          | 100000           |
| Хөрөнгийн дүн      | <b>1200000</b> | <b>1260000</b>   |
| БХ өглөг           | 240000         | 240000           |
| УХ өглөг           | 500000         | 520000           |
| Өглөгийн дүн       | 740 000        | 760000           |
| Энгийн хувьцаа     | 600000         |                  |
| Хур.алдагдал       | (140000)       |                  |
| ХЭ Өмч:            | 460000         |                  |
| Өглөг ба ХЭӨ дүн   | <b>1200000</b> |                  |

1260000-760000=500000 /Цэвэр хөрөнгийн зах зээлийн үнэ/

А компанийн бүртгэлд дараахь бичилтийг хийнэ.

|    |                                   |        |
|----|-----------------------------------|--------|
| a/ | Б компанийн цэвэр хөрөнгөн дэх ХО | 440000 |
|    | Мөнгөн хөрөнгө                    | 440000 |
| б/ | Эргэлтийн хөрөнгө                 | 200000 |
|    | БХХО                              | 60000  |
|    | Үндсэн хөрөнгө                    | 900000 |
|    | Биет бус хөрөнгө                  | 100000 |
|    | БХ өглөг                          | 240000 |
|    | УХ өглөг                          | 500000 |
|    | УХ өглөгийн урамшуулал            | 20000  |
|    | "Б" компанийн ц/х дэх ХО          | 440000 |
|    | Сөрөг гүүдвил                     | 60000  |

**Бизнесийн нэгдлийн орлогын татварын бүртгэл**

Бизнесийн нэгдлийн орлогын татварыг:

1. Худалдан авч эзэмшсэн охин компанийн цэвэр хөрөнгийн дансны үнээс давж буй тухайн үеийн зах зээлийн үнэнд;
2. Компани хоорондын хөрөнгө оруулалтаар охин компанийн цэвэр ашгаас толгой компанид оногдох хэсэгт;

3. Компани хоорондын хүлээгдэж буй хэрэгжээгүй ашигт ; тус тус ноогдуулж бүртгэнэ.

"Сэлэнгэ" ХК нь "Онон" компанийн цэвэр хөрөнгийг худалдан авахдаа 800000 төг төлжээ. Онон компанийн доорх хөрөнгийнхөөс бусад цэвэр хөрөнгийн тухайн үеийн зах зээлийн үнэ нь балансын дүнтэйгээ тэнцүү байв.

Тухайн үеийн      Балансын дүн      Зөрүү      Ашиглах

| Хөрөнгө         | зах зээлийн үнэ | татварын суурь | хугацаа           |
|-----------------|-----------------|----------------|-------------------|
| Бараа (ЭАЭЗ)    | 100000          | 80000          | 20000             |
| Газар           | 250000          | 220000         | 30000             |
| Барилга         | 640000          | 500000         | 40000      20 жил |
| Тоног төхөөрөмж | 120000          | 100000         | 20000      5 жил  |
| <b>Дүн</b>      | <b>1110000</b>  | <b>900000</b>  | <b>210000</b>     |

Онон компанийн бусад хөрөнгө болон өглөгийн балансын дүн нь харгалзан 390000 төг ба 650000 төг бөгөөд эдгээр дүн нь тухайн үеийн зах зээлийн үнэтэйгээ тэнцүү байсан. Орлогын татварын шатлал 40% гэвэл: Дээрх зөрүү 210000төг.т ноогдох татварыг хойшлуулан Сэлэнгэ компанийн бүртгэлд дараах журналын бичилтийг хийнэ. Үүнд:

|     |                                    |        |
|-----|------------------------------------|--------|
| I.  | Онон компани дахь хөрөнгө оруулалт | 800000 |
|     | Мөнгөн хөрөнгө                     | 800000 |
| II. | Бараа материал                     | 100000 |
|     | Газар                              | 250000 |
|     | Барилга                            | 640000 |
|     | Тоног төхөөрөмж                    | 120000 |
|     | Бусад хөрөнгө                      | 390000 |
|     | Гудвилл                            | 34000  |
|     | Орлогын хойшлогдсон татварын өглөг | 84000  |
|     | Бусад өглөг                        | 650000 |
|     | Онон компани дахь хөрөнгө оруулалт | 800000 |

Гүүдвилийн тооцоолол:

$$(800000-(1110000+390000))-(84000+650000))=34000$$

Компани хоорондын хөрөнгө оруулалтаар охин компанийн ашгаас толгой компанид оногдох хэсэгт ноогдох орлогын татварыг дараах жишээгээр авч үзье.

"Дөл" компанийн энгийн хувьцааны 75%-ийг "Оч" ХК 2007 оны 4 сарын 1-нд мөнгөөр худалдан авч эзэмшжээ. Энэ үед "Оч ХК-ийн гүүдвил 30000 төг болов. Дөл компанийн цэвэр хөрөнгийн тухайн үеийн зах зээлийн үнийг балансын дүнгээр авсан байна. Гүүдвилийн хорогдуулга болон капиталын аргаар тооцсон компани хоорондын хөрөнгө оруулалтын орлого (ашиг) –ыг оролцуулаагүйгээр Оч ХК-ийн татвар тооцохын өмнөх ашиг 100000 төг, Дөл " компанийн татвар тооцохын өмнөх ашиг 50000 төг. 2007 онд Дөл " компанийн зарлаж төлсөн ноогдол ашиг 10000 төг бөгөөд орлогын татварын шатлал 2 компанид 40% байгаа. Бизнесийн нэгдлийн охин компаниас хүртсэн ашгийн 80% -ийг татвараас чөлөөлдөг. Компани хоорондын ажил гүйлгээнээс ямар нэг ашиг бий болоогүй гэвэл 2007 оны 3 сарын 31-нд Дөл компанийн бүртгэлийн бичилт дараах байдалтай болно. Үүнд.

|   |       |
|---|-------|
| Орлогын татварын зардал                                   | 20000 |
| Орлогын татварын өглөг<br>(50000*40%)                     | 20000 |
| Харин Оч ХК-ийн бүртгэлд дараах бичилтүүд хийгдэнэ. Үүнд: |       |
| А. Хорогдуулгын зардал                                    | 750   |
| Дөл компани дах ХО<br>(30000/40)                          | 750   |
| Б. Орлогын татварын зардал                                | 40000 |
| Орлогын татварын өглөг<br>(100000*40%)                    | 40000 |
| В. Мөнгөн хөрөнгө   | 7500  |
| Дөл компани дах ХО<br>(10000*75%)                         | 7500  |
| Г. Дөл компани дах ХО                                     | 22500 |
| Компани хоорондын ХО ашиг<br>((50000-20000)*75%)          | 22500 |
| Д. Орлогын татварын зардал                                | 1800  |
| Орлогын татварын өглөг                                    | 600   |
| Орлогын хойш. татварын өглөг                              | 1200  |

Компани хоорондын хөрөнгө оруулалтаар толгой компанид оногдох ашигт ноогдох орлогын татвар дараах байдлаар тооцогдоно.

|                                       |       |
|---------------------------------------|-------|
| Охин компанийн цэвэр ашиг             | 30000 |
| Толгой компанид ноогдох нь (30000*75) | 22500 |
| Татварын хөнгөлөлт (22500*80)         | 18000 |
| Орлогын татварт хамаарах дүн          | 4500  |
| Орлогын татварын зардал (4500*40)     | 1800  |

Ноогдол ашиг авсан тул тайлант үед төлбөл зохих:

|                               |                 |
|-------------------------------|-----------------|
| Татварын өглөг (7500*20%*40%) | 600             |
| Хойшлогдсон татварын өглөг    | 1200            |
| Орлогын татварын зардал       | 1800 төг болно. |

Компани хоорондын хэрэгжээгүй буюу хүлээгдэж буй ашигт ноогдох орлогын татварыг дараах жишээгээр тодорхойлъя.

Бизнесийн нэгдлийн эхний жил болох 2007 онд охин компани "Б" толгой компани "А"-даа 96000 төгрөгийн өртөгтэй барааг 120000 төгрөгөөр борлуулсан. Тайлант хугацаанд толгой компани авсан барааныхаа 70%-ийг гадны компанид худалдсан гэвэл 12 сарын 31-нд А болон Б компанийн

санхүүгийн тайланг нэгтгэх ажлын хүснэгтэд компани хоорондын гүйлгээгээр барааны эцсийн үлдэгдэлд үлдсэн ашгийг доорх байдлаар устгаж бичнэ.

|  |        |
|--|--------|
| Компани хоорондын борлуулалт -Б            | 120000 |
| Компани хоорондын борлуулсан барааны өртөг | 96000  |
| Борлуулсан барааны өртөг -А                | 16000  |
| Бараа -А                                   | 8000   |

"Б" компани А-д бараагаа борлуулсны 24000 төгрөгийн ашгаас тооцож орлогын татварын зардлаа тодорхойлсон бөгөөд үүнээс 3200 төг.-ийн татвар нь барааны эцсийн үлдэгдэл дэх хэрэгжээгүй ашигт (8000 төг.) ноогдуулсан татвар тул орлогын татварын дараах нэмэлт зохицуулалтыг дансны бичилтээр харуулах ёстой.

|                                  |      |
|----------------------------------|------|
| * Урьдчилж төлсөн орлогын татвар | 3200 |
| Орлогын татварын зардал          | 3200 |

Түүнчлэн толгой болон охин компанийн хооронд газар борлуулсан, тоног төхөөрөмж борлуулсан зэрэг ажил гүйлгээгээр бий болсон хүлээгдэж буй хэрэгжээгүй ашигт ноогдох орлогын татварыг тооцож дээрх бараа материалын гүйлгээтэй адилаар урьдчилж төлсөн орлогын татвар болгон бүртгэх шаардлагатай байдаг.